



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 162

Арвайхээр

Ч.Хишигсүрэн, З.Дэмбэрэл, Б.Алтангадас
нарт буцалтгүй тусламж олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Дэлгэрэхийн 3 дугаар багийн иргэн Ч.Хишигсүрэн, Арвайхээрийн 5 дугаар багийн иргэн З.Дэмбэрэл, Ноёны 10 дугаар багийн иргэн Б.Алтангадас нарт санхүүгийн дэмжлэг үзүүлж тус бүр 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Ж.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ